


МОНГОЛ ИСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖИЛТЭЙ АЖИЛААГ
**ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**
1510 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дугаар хороо,
Баян Чойруу 3, Утас: 32 65 62, 63; факс: (976-11) 32 62 74,
E-mail: sonoguliy@elnet.mn, info@election.mn

2017-05-24 № 2/1398
ТАВНИЙ _____-ны № _____-т

Чиглэл өгөх тухай

Сонгуулийн тухай хуулийн 61.1 дэх хэсэгт Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний бүртгэл, мэдээллийн сан дахь сонгогчийн бүртгэлд үндэслэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн үйлдэнэ гэж завсрын дагуу Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны А/211 тоот тушаалаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулах, нягтлан шалгах ажлыг зохион байгуулах "Ажлын хэсэг" байгуулагдаж, 88 зүйл бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиглаж байна.

Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэхтэй холбогдуулан улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх үүрэг, сонгуулийн вйл ажиллагаатай холбогдуулан төрийн албан хаагчийн хүлээх үүрэг, хариуцлага, хориглох зүйлийг Сонгуулийн тухай хуулийн 4.7, 11.1, 29.4, 31.17, 33.16, 70.4, 70.5.2 болон 61-86 дугаар зүйлд тодорхой зохицуулсан.

Сонгуулийн тухай хууль тогтоомжоор хүлээсэн улсын бүртгэлийн байгууллагын үүргийг хэрэгжүүлдэг газар, хэлтсийн дарга нар улс төрийн болон хичнээнхэн аливаа нөлөөнд авталгүй, Сонгуулийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж, ажиглахыг чиглэл болгож байна.

ДАРГА  Р.СОДХУУ